



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧИЙН ХУРАЛЫН  
ТОГТООЛ

2019 оны 11 сарын 30 өдөр

№ 9/04

"Тохижилт, ногоон байгууламжийг  
нэмэгдүүлэх жил" болгон зарлах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 1, 19 дүгээр зүйлийн 1 дэх заалтуудыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Иргэдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах нөхцлийг сайжруулах, орчны бохирдлыг бууруулах, төв суурин газрын ногоон байгууламжийг нэмэгдүүлэх зорилгоор 2019 оныг "Тохижилт, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх жил" болгон зарласугай.

2. "Тохижилт, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх жил"-ийн хүрээнд зохион байгуулах ажлын төлөвлөгөөг баталж, удирдлага зохион байгуулалтаар ханган, хэрэгжилтэнд хяналт тавьж, үр дүнг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд танилцуулахыг аймгийн Засаг дарга /Г.Ганболд/-д даалгасугай.

3. 2019 оныг "Тохижилт, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх жил" болгон зарласантай холбогдуулан орон нутгийн хэмжээнд зохион байгуулах ажлын төлөвлөгөөг боловсруулан, сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулан хэрэгжүүлж ажиллахыг сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

ДАРГА.



А.ИШДОРЖ



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
ТАРАГТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2019 оны 02 сарын 12 өдөр

Дугаар 1/28

Хир 1/11

Ажлын хэсэг байгуулах тухай

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын "Тохижилт, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх жил" болгон зарлах тухай 2018 оны 09/04 дүгээр тогтоолыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын хэмжээнд "Тохижилт, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх жил" -ийн ажлыг зохион байгуулах ажлын хэсгийг хавсралтаар баталсугай.
2. Тохижилт, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх жилийн хүрээнд зохион байгуулах ажлын төлөвлөгөөг сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар батлуулж хэрэгжилтэнд хяналт тавьж, үр дүнг тайлагнаж ажиллахыг Засаг даргын орлогч ажлын хэсгийн ахлагч (М.Төрболд)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Х. ДАШДЭЛЭГ

Сумын Засаг даргын 2019 оны ᠒ дугаар сарын  
᠒-ны өдрийн ᠒᠑ дугаар захирамжийн хавсралт

### АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч: М.Төрболд- Засаг даргын орлогч  
Нарийн бичгийн дарга: Ж.Батзориг- Байгаль орчны хяналтын улсын байцаагч  
Гишүүд: Б.Батцэцэг- Засаг даргын Тамгын газрын дарга  
Д.Энхбаатар- Эрүүл мэндийн төвийн дарга  
Ц.Хоролмаа- ЕБСургуулийн захирал  
Х.Должинсүрэн- Цэцэрлэгийн эрхлэгч  
Т.Лхагважав- Соёлын төвийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч  
Д.Ууганбаяр- Туяа багийн ЕБСургуулийн захирал  
Р.Адъяадулам- Бүргэтэй хайрхан ХХК-ы менежер  
Ч.Батжаргал- Төрийн банкны Тарагт тооцооны төвийн эрхлэгч  
Э.Даваасүрэн- ХААН банкны Тарагт тооцооны төвийн эрхлэгч  
З.Солонго- Өлзийт дэлгүүрийн эзэн  
Р.Адъяа- Иргэний төлөөлөл